

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



### Төв Ази, Ойрхи Дорнод, Хойд Африкийн эмэгтэйчүүдэд зориулсан залбирал 1

Хэрвээ та Христэд итгэснээсээ болж хавчигдвал ямар ха риу үйлдэл үзүүлэхээ бодож байсан үү? 2024 онд Хойд Солонгос, Сомали, Ливи болон Африкийн 26 улсын иргэ д Христэд итгэснийхээ улмаас хамгийн их хавчлага дара мтанд өртөөд байна. Нигерт итгэлийнхээ төлөө 4100 гар үй Христэд итгэгч иргэд амиа алдсан байдаг. Ийнхүү ча нгаар хашхиран залбирч чадахгүй чимээгүйхэн зовлонто й, цөхөрсөн зүрх сэтгэлийн хашхиралтыг Бурхан Аав анх ааралтайгаар сонсдог. Бидний зуучлан залбиралаар дам жуулан тэднийг хавчлагаас чөлөөлөх болтугай.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, хүний наймаанд урхинд орсон бүх хүмүүсийг бие махбод, сүнслэг байдлаар чөлөөлөхийн тулд Та ажиллаач. Та биднийг боолчлолоос чөлөөлөхийн тулд Есүсийг илгээсэн билээ. (Лук 4:18-19)
2. Эзэн минь, Туркменистаны эрчүүдэд эхнэртээ хайр, эелдэг байдал, үнэнчээр хандахад туслаач. Нөхөртэйгээ харилцах харилцаа нь асуудалтай байгаа эмэгтэйчүүдэд урам зоригийг Та өгөх болтугай. (Еф. 5:25)
3. Эзэн минь, Казахстан дахь сүм чуулганы удирдагчид Тантай нэгдээсэй хэмээн бид залбирч байна. Тэд хамтран үйлчилж, санал зөрөлдөөнөө нигүүлслээр шийдвэрлэх боломжийг Та олгооч. (1 Кор. 1:10)
4. Нийгэм, соёлын сорилттой тулгарч буй Марокко эмэгтэйчүүдэд Бурханы аюулгүй байдал, хамгаалалт байх

болтугай. Тэдэнд мэргэжил, боловсрол эзэмших эрх нь нээлттэй болохын төлөө залбирч байна. (Ис. 41:10)

5. Аав аа, Узбекистан улсад гэр бүлийнхээ хүрээнд бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг Та хамгаалаач. Энэ хорон мууг даван туулах тэсвэр тэвчээрийг тэдэнд та өгөх болтугай. (2 Сам. 22:3-4)
6. Аав аа, манай Ойрхи Дорнодын багууд өөрсдийн дижитал платформуур дамжуулан араб эмэгтэйчүүдийг Бурханы үгээр дамжуулан мэргэн ухаан, хүч чадлаар хүчирхэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх болтугай. (Сур. 31:25)
7. Эзэн минь, Киргизийн цагаачлалын улмаас тусгаарлагдсан гэр бүлүүдийн зовлон зүдгүүрийг хөнгөлж, итгэл найдвар өгөөч. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийг Та хамгаалж, халамжлах болтугай. (Ром. 12:12)
8. Аав аа, Тажикистан дахь эмэгтэйчүүдэд авралыг өгөөч. Тэд Есүс Христээс хайр, найдвар, итгэл, тусламжийг эрэлхийлэх болтугай. (Дуу. 121:1)
9. Эзэн минь, Каракалпакстан дахь гэр бүл салалт, архидалт зэрэгт өртсөн гэр бүлүүдийн төлөө залбирч байна. Тэдний гэрлэлтийг сэргээж, хосуудын хоорондын харилцааг Та сэргээгээч. (Мат. 19:6)
10. Бурхан минь, олон хүн чамаас нүүр буруулсан энэ хүнд хэцүү цаг үед Турк сүмүүд гэрэлтэх болтугай. Туркийн Христэд итгэгчид харилцаандаа Бурханыг тусгаж, хамт олон нь та нарын сэтгэлийг хөдөлгөх болтугай. (Дан. 12:3)
11. Эзэн минь, Хойд Киприйн эмэгтэйчүүд сайн ажил, хангалттай орлого олохыг чамаас хүсэх болтугай. (Флп 4:19)
12. Бурхан минь, Туркменистанд олон эмэгтэйчүүд эдгээхийн тулд эсвэл нөхрийнхөө өмнөөс хар ид шид хийдэг. Тэд үнэнийг сурч, харанхуйн хүчнээс ангид байх болтугай. (Дэд хууль 18:10-12)
13. Аав аа, Казахстанд шинээр итгэгчдийн итгэл бэхжиж, Их Эзэнд бүх зүрх сэтгэлээрээ итгээсэй гэж бид залбирч байна. (1 Кор. 16:13)
14. Өршөөнгүй Бурхан минь ээ, Оман дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тулгарсан эмэгтэйчүүдэд хамгаалалт, шударга ёс, эдгэрэлийг өгөөч. (Сур. 18:10)

15. Эзэн минь, зарим нөхрийнхөө болон бусад хүмүүсийн сөрөг хандлагыг үл харгалзан Узбекистаны эмэгтэйчүүд Таны жинхэнэ мөн чанар, үнэ цэнийг тань хүлээн зөвшөөрөөсэй гэж бид залбирч байна. (Эх. 1:27)
16. Бурхан минь, Киргизийн залуу үеийнхэнд аврал авчрах болтугай. Тэд таныг уламжлал ёсоор биш, харин Тантай харилцах харилцаандаа Таныг чин сэтгэлээсээ дагахыг хүсэх болтугай. (Мат. 3:8–10)
17. Бурхан минь, соёл, шашны уламжлалаас болоод боловсрол эзэмших боломжгүй, гэр бүл, нийгэмдээ ямар ч дуу хоолойгүй Тажикистан охидын төлөө залбирч байна. (Дуу. 32:8)
18. Аав аа, Каракалпакстаны эмэгтэйчүүд өөрсдийгөө эхнэр, ээжийн хувьд хангалттай сайн байгаагүй хэмээн өөрийгөө буруутгадаг буруу мэдрэмжүүдээсээ салахын төлөө бид залбирч байна. (Дуу. 31:1)
19. Бурхан минь, бид Тунисын итгэгч эмэгтэйчүүдийн оюун санааны сэргэлт, өсөлт хөгжилтийн төлөө залбирч байна. Мөн Египетийн чуулганы эмэгтэй удирдагчдыг хүчирхэгжүүлж, урамшуулаач хэмээн Танаас гуйж байна. (2 Петр. 3:18)
20. Аав аа, бид Туркийн Христэд итгэгч гэр бүлүүдэд итгэлцлийн хэлхээ холбоо тогтохын төлөө залбирч байна. Таны Сүнс тэднийг хайраар нэгтгэх болтугай. (Кол. 3:14)
21. Бурхан минь, эдийн засгийн хямралд нэрвэгдсэн Ливаны эмэгтэйчүүдэд итгэл найдвар, эдгэрэлт, хангамж өгөөч. Таныг таньж мэдэхгүй хүмүүст хүрч, Сайн мэдээгээр дамжуулан тэдэнд жинхэнэ амар амгалан ирэх болтугай. (Дуу. 34:18)
22. Эзэн минь, Каракалпакстаны эмэгтэйчүүдэд таныг амьдралдаа нэн тэргүүнд тавьж, бусад үүрэг амлалтыг үл харгалзан чуулганы мөргөл хүндэтгэлийн үйл ажиллагаанд тогтмол оролцоход нь Туслаач хэмээн бид Танаас гуйж байна. (Евр. 10:25)
23. Казахстанд эхнэр нь хүчирхийлэлд өртснөө эрх баригчдад мэдэгдэж, хамгаалагдах боломжтой гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох хууль батлагдсанд Эзэн Таныг магтъя. (Кол. 3:19)
24. Эзэн минь, хүний үндсэн эрхийг хамгаалж буй Ойрхи Дорнодын эмэгтэйчүүдэд хамгаалалт, эр зоригийг өгөөч. Тэд Танаас жинхэнэ эрх чөлөөг олж мэдэхийн тулд манай баг сайн мэдээгээр тэдэнд хүрэх болтугай. (Йош. 1:9)
25. Хайртай Аав аа, Узбекистаны итгэгчдэд сайн мэдээг түгээх мэргэн ухаан, эр зоригийг өгөөч. Таны сайн мэдээг хүлээж авахад нээлттэй хүмүүс рүү тэднийг хөтлөөч. (Иаков 1:5)
26. Эзэн минь, тусламж хэрэгтэй хүмүүст туслахын тулд боловсрол, эмнэлгийн системийг өөрчлөхөд Киргизийн удирдагчдад мэргэн ухааныг Та тэдэнд өгөөч. (Хаадын дээд 3:9)
27. Бид Иорданы итгэгчдийн дунд сүнслэг өсөлт, нөхөрлөлийг бий болгохын тулд Та Өөрийн үгээрээ

тэднийг дүүргэж нийгэм дэх эмэгтэйчүүдтэй сайн мэдээг хуваалцах хүчийг өгөөрэй. (Кол. 1:10)

28. Бурхан минь, Йемений дайнд нэрвэгдсэн бүс нутгуудын бэлэвсэн эхнэр, өрх толгойлсон эхчүүдийг аюулгүй байлгаж, тэдэнд Та анхаарлаа хандуулаач. Христэд итгэгчид Танаас хүч чадал, итгэл найдвараа олох болтугай. (Дуу. 91:1–2)
29. Аав аа, Христэд итгэх итгэлийнхээ улмаас гэр бүлээрээ хавчигдаж байгаа тосгонд амьдардаг Тажик эмэгтэйчүүдийг Та хүчирхэгжүүлээч. (Мат. 5:11)
30. Турк улсад бие махбодь болон оюун санааны хувьд зовж шаналж буй хүмүүс Танаар эдгэрч, амьдралын найдварыг олж аваасай гэж бид залбирч байна, Эзэн минь. Тэднийг урхинд оруулсан бүх зүйлээс зовлон зүдгүүрээс ангижрах болтугай. (Ром. 8:2)

### Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Аялал зугаалгын цаг эхэлсэн энэ үед хүүхдүүд маш ихээр гол усанд эндэж байна. Эзэн Та бяцхан хүүхдүүдийн хамгаалагч, арал нь байгаач хэмээн залбирч байна.
2. Сонгуулийн үр дүнд гарсан шинэ засгийн газар ард иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан, засгийн газраас хамаарсан зөв, шударга шийдвэрүүдийг гаргаж, ард иргэдийнхээ амьдралыг эерэг сайнаар өөрчлөхөд Та тэдэнд туслаач
3. Монгол сүм чуулганууд үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэртээ Эзэний хайрыг харуулан, байгаа газар бүртээ өөрчлөлтийг авчрахыг төлөө залбирч байна.

#### 후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송  
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.